



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/59/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2023 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Лхагвацэнд
Утас: 263533 Цахим хаяг: lkhagvatsendd@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Нийслэл аудит" ХХК
Захирал: Т.Сугарсүрэн
Утас: 9911-5395 Цахим хаяг: info@niislelaudit.mn
Утас: 7011-0095

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.2 Албан шаардлага	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТТХ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
ЗГ	Засгийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.ЦЭРЭНБАТ ТАНАА

2023.03.15 № 07/562
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Эрдэнэс оюу толгой ХХК нь тайлант онд олон жилийн турш үйл ажиллагааг зээлээр санхүүжүүлэх тогтолцоог өөрчилж, санхүүжилтийн эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагаанаас бүрдүүлэх зорилтын хүрээнд Оюу толгой төсөлд хяналт тавих төслийн менежментийг сайжруулах гэрээний дагуу 20,944.4 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-1/1412 тоот албан бичгийн дагуу 557.4 сая төгрөгийн ногдол ашгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Толгой компани болох Эрдэнэс монгол ХХК-д төлөх зээл, зээлийн хүүгийн төлбөрөөс 2,100.0 сая төгрөгийн өр төлбөрийг төлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 388 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,348,962,236.92	9,065,257,607.77
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	13,882,461.09	4,804,276.17
1.1.4	Бусад авлага	16,036,363.65	11,438,087.65
1.1.6	Бараа материал		
1.1.7.1	Урьдчилж төлсөн зардал	62,706,900.00	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,441,587,961.66	9,081,499,971.59
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	109,086,714.69	317,682,744.45
1.2.2	Биет бус хөрөнгө	11,103,694.00	34,957,627.00
1.2.9	Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,747,782,420,000.00	2,747,782,420,000.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	101,336,195.08	101,336,195.08
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,748,003,946,603.77	2,748,236,396,566.52
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,753,445,534,565.43	2,757,317,896,538.12
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,076,427,369.00	-
2.1.1.3	Татварын өр	596,194,953.01	1,937,514,102.76
2.1.1.4	НДШ-ийн өглөг	4,673,769.72	-
2.1.1.6	Хүүгийн өглөг	4,552,001,905.36	5,070,986,656.53
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	9,744,337.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,229,297,997.09	7,018,245,096.29
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	143,616,907.69
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	9,104,329,430.00	7,437,342,391.16
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	9,104,329,430.00	7,580,959,298.85
2.2	Өр төлбөрийн нийт дүн	15,333,627,427.09	14,594,335,115.69
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	300,000,000.00	300,000,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,747,782,420,000.00	2,747,782,420,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(9,970,512,861.66)	(5,363,727,857.03)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,738,111,907,138.34	2,742,718,692,142.97
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,753,445,534,565.43	2,757,317,896,538.12

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	20,944,418,691.82
2	Борлуулалтын өртөг	-	
3	Нийт ашиг (алдагдал)	-	20,944,418,691.82
5	Хүүгийн орлого	-	-
8	Бусад орлого	5,698,825,000.00	315,000.00
10	Ерөнхий удирдлагын зардал	3,378,412,659.16	15,583,562,375.91
11	Санхүүгийн зардал	900,000,000.00	951,997,712.33
12	Бусад зардал	163,575,280.12	17,960,896.45
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(200.42)	2,109,918,162.48
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,256,836,860.30	6,501,130,869.60
19	Орлогын татварын зардал	71,020,607.02	508,292,268.91
	Хойшлогдсон татварын зардал (орлого)	71,020,607.02	143,616,907.69
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,114,795,646.26	5,849,221,693.00
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,114,795,646.26	5,849,221,693.00
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	1,114,795,646.26	5,849,221,693.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00	2,689,647,010,000.00	(11,257,665,310.01)	2,678,689,344,689.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			172,356,802.10	172,356,802.10
Залруулсан үлдэгдэл	300,000,000.00	2,689,647,010,000.00	(11,085,308,507.92)	2,678,861,701,492.09
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1,114,795,646.26	1,114,795,646.26
Өмчид гарсан өөрчлөлт		58,135,410,000.00		58,135,410,000.00
Зарласан ногдол ашиг				
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(9,970,512,861.66)	2,738,111,907,138.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(1,242,436,688.37)	(1,242,436,688.37)
Залруулсан үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(11,212,949,550.03)	2,736,869,470,449.97
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			5,849,221,693.00	5,849,221,693.00
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ногдол ашиг				
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	-5,363,727,857.03	2,742,718,692,142.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,698,825,000.00	23,039,175,561.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	23,038,860,561.00
	Бусад мөнгөн орлого	5,698,825,000.00	315,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	1,809,156,023.47	17,517,167,072.25
	Ажиллагчдад төлсөн	735,813,073.00	1,821,029,000.57
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	235,000,000.00	360,000,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	29,555,065.00	26,622,639.63
	Ашиглалтын зардалд төлсөн		
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,965,597.00	19,153,900.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		300,000,000.00
	Татварын байгууллагад төлсөн	75,480,315.55	4,543,338,378.59
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	721,341,972.92	10,447,023,153.46
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,889,668,976.53	5,522,008,488.75
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,828,840.00	
	Хүлээн авсан хүүгийн орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буОюуцаан төлөлт	3,828,840.00	
2.2	Мөнгөн зарлагын дүн	120,612,573.64	354,167,223.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	85,356,610.00	324,676,223.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	11,000,000.00	29,491,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	24,255,963.64	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(116,783,733.64)	(354,167,223.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,530,650,000.00	
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,530,650,000.00	-
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн		2,876,427,369.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		2,100,000,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		219,027,369.00
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		557,400,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,530,650,000.00	(2,876,427,369.00)
4	Валютин ханшийн зөрүү	(200.42)	1,424,881,474.11
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,303,535,042.47	3,716,295,370.85
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	45,427,194.45	5,348,962,236.92
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,348,962,236.92	9,065,257,607.77

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Орлогын төрөл					
1	Бусад орлого	5,698,825,000.00	-			-
2	Ажил, үйлчилгээний орлого		12,959,090,909.00	20,944,418,691.82	(7,985,327,782.82)	161.62
	Цалин нийгмийн хамгааллын зардал	267,069,281.53	2,265,587,120.00	1,476,950,193.23	788,636,926.77	65.19
1	Цалин хөлс шагнал	201,201,125.22	1,884,160,000.00	1,243,822,693.23	640,337,306.77	66.01
2	Нэмэгдэл цалин	46,156,000.00	111,952,000.00	70,090,000.00	41,862,000.00	62.61
3	Нийгмийн даатгалын шимтгэл	19,712,156.31	269,475,120.00	163,037,500.00	106,437,620.00	60.50
	Урсгал зардлын төсөв	2,344,967,719.58	12,616,542,780.00	13,997,190,047.49	(1,380,514,500.94)	110.94
1	Бичиг хэргийн зардал	9,985,000.00	12,021,100.00	9,619,000.00	2,402,100.00	80.02
2	Веб сайт интернэтийн зардал	8,923,000.00	35,344,000.00	27,909,000.00	7,435,000.00	78.96
3	Шуудан холбооны зардал	5,000,000.00	5,600,000.00	3,664,000.00	1,936,000.00	65.43
4	Машин үйлчилгээ сэлбэг	8,195,330.00	17,600,000.00	4,230,000.00	13,370,000.00	24.03
5	Гэрээт ажлын зардал	90,000,000.00	126,000,000.00	125,100,000.00	900,000.00	99.29
6	Санхүүгийн тайлан баталгаажуулах зардал	9,900,000.00	15,000,000.00	9,900,000.00	5,100,000.00	66.00
7	Гадаад, дотоод сургалт, зар сурталчилгааны зардал	26,099,000.00	939,300,000.00	350,703,186.91	588,596,813.09	37.34
8	Шатахууны зардал	11,949,724.27	36,876,000.00	18,800,000.00	18,076,000.00	50.98
9	Байрны урсгал зардал	-	25,000,000.00	-	25,000,000.00	0.00
10	Зочид төлөөлөгчийн зардал	1,242,800.00	700,000,000.00	269,200,000.00	430,800,000.00	38.46
11	Ном, хэвлэл захиалгын зардал	2,100,000.00	3,909,200.00	2,848,500.00	1,060,700.00	72.87
12	Гадаад томилолтын зардал		150,000,000.00	95,849,707.00	54,150,293.00	63.90
13	Дотоод томилолтын зардал	9,123,978.00	40,000,000.00	27,250,000.00	12,750,000.00	68.13
14	Түрээсийн зардал	136,764,822.27	516,146,400.00	114,644,072.00	401,502,328.00	22.21
15	Ажилтнуудын нийгмийн асуудал, арга хэмжээ	24,698,341.27	72,268,000.00	6,780,000.00	65,488,000.00	9.38
17	Хангамжийн материалын зардал	13,000,000.00	18,028,080.00	17,056,000.00	972,080.00	94.61
18	Даатгал ба эрсдэлийн зардал	315,000.00	18,450,000.00	8,250,000.00	10,200,000.00	44.72
19	Зөвлөх үйлчилгээ, судалгааны зардал	1,987,670,723.77	9,885,000,000.00	12,905,253,815.03	(3,020,253,815.03)	130.55
	Нийт зардлын дүн	2,612,037,001.11	14,882,129,900.00	15,474,007,474.17	(591,877,574.17)	103.98
	Шаардлагатай хөрөнгө оруулалт	43,793,390.00	1,325,757,000.00	364,391,919.64	961,365,080.36	27.49
1	Компьютер, дагалдах хэрэгсэл	4,443,390.00	201,800,000.00	187,650,919.64	14,149,080.36	92.99
2	Тавилга, эд хогшил	19,350,000.00	148,327,000.00		148,327,000.00	0.00
3	Тээврийн хэрэгсэл	-	570,000,000.00	147,250,000.00	422,750,000.00	25.83
4	Архивын программ хангамж, сервер, шаардлагатай тоног төхөөрөмж	20,000,000.00	405,630,000.00	29,491,000.00	376,139,000.00	7.27
	Нийт дүн	2,655,830,391.11	16,207,886,900.00	15,838,399,393.81	369,487,506.19	97.72

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн зорилго нь Компанийн дүрмийн 3.1-д "Монгол Улс, ард иргэдийнхээ эрх ашгийг тэргүүн ээлжид тавьж, төслийн өгөөжийг дээшлүүлэн, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх, удирдах эрхийг хэрэгжүүлэх" явдал юм.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Компанийн дүрмийн 3.3-т "Оюу Толгой ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх, Хувьцаа эзэмшигчийн хувьд Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагаанд оролцох, Оюу Толгойн ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх, төрд ногдох ашгийг төвлөрүүлэх" гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг компанийн үүсгэн байгуулагч бөгөөд төрийн мэдлийн хувьцааг эзэмшигч "Эрдэнэс Монгол" ХХК байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Эрдэнэс оюу толгой ХХК-ийг Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 348 дугаар тогтоол, "Эрдэнэс Монгол" ХХК (тухайн үеийн "Эрдэнэс МГЛ" ХХК)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолуудыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах" гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тус компанийн толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл томилж байгаа нь Компанийн тухай тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалттай нийцэж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан бүтцийн дагуу Гүйцэтгэх захирал, Дэд захирал, Зөвлөх, 5 хэлтэст нийт 40 орон тоотойгоор ажиллахаар төлөвлөгдсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс тус тогтоолд "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн хурлын 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, "Дэд захирал" болон "Зөвлөх"-ийн албан тушаалыг хасаж, 38 орон тоотой болгон өөрчлөн тогтоосон.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон.
2. Хувь хүний орлогын албан татварын хуульд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон.
3. Төрийн хэмнэлтийн хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдан мөрдөгдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

Эрдэнэс оюу толгой ХХК нь толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлан ажиллаж байгаа бөгөөд стандарт, хууль дүрэм журмын өөрчлөлтийг тусгасан үйл ажиллагаандаа тохирсон НБББББ-ийг боловсруулан мөрдөн ажиллах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,872.4 сая төгрөгөөр буюу 0.14 хувиар өссөн байна.

4. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,348,962.2	9,065,257.6	3,716,295.4
Авлага	29,918.8	16,242.4	(13,676.4)
Урьдчилж төлсөн тооцоо	62,706.9	-	(62,706.9)
Үндсэн хөрөнгө	109,086.8	317,682.7	208,595.9
Биет бус хөрөнгө	11,103.7	34,957.6	23,853.9
Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,747,782,420.0	2,747,782,420.0	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	101,336.2	101,336.2	-
Нийт хөрөнгө	2,753,445,534.6	2,757,317,896.5	3,872,361.9
Богино хугацаат өр төлбөр	6,229,298.0	7,018,245.1	788,947.1
Урт хугацаат өр төлбөр	9,104,329.5	7,580,959.3	(1,523,370.2)
Эздийн өмч	2,738,111,907.1	2,742,718,692.1	4,606,785.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,753,445,534.6	2,757,317,896.5	3,872,361.9

Дээрх хүснэгтээс харахад Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 9,065.3 сая төгрөг болж 3,716.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант жилийн үндсэн үйл ажиллагааны орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 16.2 сая төгрөг болж 13.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны орлогод ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварын төлөлттэй холбоотойгоор буурсан байна.

Урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 62.7 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны аудитын зөвлөмжөөр өгсөн ажил хүлээн авах гэрээний хугацаа дуусаагүй байсан 62.7 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардалд бүртгэсэн байсныг тайлант хугацаанд мэргэжлийн үйлчилгээний зардалд тусган зардлаар тооцсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 317.7 сая төгрөг болж 208.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 147.3 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 167.9 сая төгрөгийн компьютер дагалдах хэрэгсэл зэрэг нийт 315.2 сая төгрөгийн биет хөрөнгө худалдан авсан, мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А-1/2490 тоот албан бичгийн дагуу 102.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө актлан данс бүртгэлээс хассан зэрэгтэй холбоотой байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 35.0 сая төгрөг болж 23.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 26.8 сая төгрөгийн архивын программ худалдан авч капиталжуулсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 7,018.2 сая төгрөг болж 788.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны зээлийн хүүгийн зардал 519.0 сая төгрөгөөр, байгууллагад өгөх өглөг 9.7 сая төгрөгөөр, татварын өр төлбөр 1,328.9 сая төгрөг зэргээр өссөнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 7,580.9 сая төгрөг болж 1,523.4 сая төгрөгөөр буурсан нь толгой компани болох Эрдэнэс монгол ХХК-д 1,500.0 сая төгрөгийн үндсэн зээл, 300.0 сая төгрөгийн зээлийн хүү зэрэг өр төлбөр төлсөнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 2,742,718.7 сая төгрөг болж 4,606.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 5,849.2 сая төгрөгийн ашигтай ажилласантай холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 08 дугаар тушаалаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны үндсэн үйл ажиллагааны нийт орлогыг 12,959.1 сая төгрөгөөр нийт зардлыг 15,105.8 сая, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,325.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 20,944.4 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын гүйцэтгэл 20,944.4 сая төгрөг болж төлөвлөгөөнөөс 7,985.3 сая төгрөг буюу 61.8 хувиар өссөн нь "Оюу Толгой" ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 274-дүгээр тогтоолын 5-дахь хэсэгт заасны дагуу Оюу Толгой төсөлд хяналт тавихад дэмжлэг үзүүлэх, төслийг

менежментийг сайжруулах зорилгоор гэрээний үндсэн дээр далд уурхайн бүтээн байгуулалт ашиглалтад орох хүртэл, эсхүл “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-иас төсөлд хяналт тавих шаардлагагүй гэж үзэх хүртэл 2021 оноос эхлэн 4 жилийн хугацаанд, 1 жилд таван сая ам.доллараас ихгүй, нийт 20 сая ам.долларын санхүүжилт авах эрх зүйн орчныг бүрдүүлж ажиллах гэсэн гэрээний дагуу, тайлант онд ногдох 20,944.4 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орж ирсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 12,195.7 сая төгрөгөөр буюу 3.6 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь Зөвлөх үйлчилгээ, судалгааны зардал 3,120.4 сая төгрөг буюу 31.5 хувиар хэтэрсэн байна. Энэ нь “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 92 дугаар тогтоолын 7 дугаар зүйл, мөн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 103 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдсан ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа авахаар Оюу толгой төслийн гүний уурхайд төслийн менежментийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ, судалгааны ажил хийх, арбитрайн шүүхтэй холбоотой зөвлөх компани авч ажиллуулах шаардлага гарсантай холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 34 нэр төрлийн 177.4 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгсэл худалдан авсан байна.

Компани тайлант онд 5,849.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь Эрдэнэс оюу толгой ХХК-аас гүний уурхайн бүтээн байгуулалтын төсөлд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх ажлыг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүжилтийн төлбөр хүлээн авснаас шалтгаалжээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-1/1412 тоот албан бичгийн дагуу 557.4 сая төгрөгийн ногдол ашгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Эрдэнэс оюу толгой ХХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Эрдэнэс оюу толгой ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Нийслэл аудит” ХХК-ийн аудитор Д.Ариунбулган, аудиторын туслах Д.Ариунцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг “Нийслэл аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Жаргал, захирал Т.Сугарсүрэн, нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэс оюу толгой ХХК нь 2022 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 2 дүгээр сарын 14-ны өдрийн 01/40 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 3,378.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 50.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Тайлант жилд Эрдэнэс оюу толгой ХХК-ийн үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэн, орлого болон зардлын хэмжээ өссөн учир гүйцэтгэлийн материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2022 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 15,583.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 175.3 сая төгрөг гэж тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Эрдэнэс оюу толгой ХХК нь тайлант онд удирдах 3, гүйцэтгэх 35, үйлчилгээний ажилтан 1 нийт 39 орон тоо батлагдсанаас Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэлээр 1 удирдах, 25 гүйцэтгэх, 1 үйлчилгээний ажилтан нийт 27 орон тоотойгоор ажиллаж нийт 12 ажлын байранд шинээр ажилтан алба хаагч аваагүй байна.

Тайлант хугацаанд зочид төлөөлөгчдөд бэлэг, дурсгалын зүйл худалдан авах зардалд 4.6 сая төгрөгийн зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргахгүй арилгах албан шаардлага хүргүүллээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэс оюу толгой ХХК нь 2022 онд 4,514.8 сая төгрөгийн 50 мэдээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд худалдан авах ажиллагааны төвлөгөөг 1,841.9 сая төгрөгөөр баталсан байна. ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу таван удаагийн нээлттэй тендер шалгаруулалт зарлаж 364.4 сая төгрөгийн суудлын автомшин, компьютер, дагалдах хэрэгсэл, программ хангамжийн худалдан авалт хийсэн байна. Мөн 390.0 сая төгрөгийн туулах чадвар сайтай суудлын автомашин худалдан авах, 370.6 сая төгрөгийн уул уурхайн программ хангамж худалдан авах нийт 760.6 сая төгрөгийн тендер амжилтгүй болсон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн зарим заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 2,460.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 4.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 3.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	4,833.7			
Зөвлөмж	1	3,051.9	1	3,051.9	100
Нийт дүн	2	7,885.6	1	3,051.9	38.7

Тайлант онд Эрдэнэс оюу толгой ХХК-д Оюу толгойн гэрээний зүйл заалтууд дээр харилцан тохиролцолд хүрэх ажлын хэсэг байгуулагдан энэ ажлын шугамаар гадаад зочид төлөөгчдөд гарын бэлэг өгөх шаардлага гарсан тул энэ албан шаардлагыг биелүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар зөвлөх үйлчилгээ, судалгааны ажлын зардлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,162.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3,157.7 сая төгрөгийн 7 алдааг залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Валютин харилцах дансны гүйлгээний болон үлдэгдлийн ханшийн тэгшитгэл хийхдээ 1,561.6 сая төгрөгөөр зөрүүтэй тооцоолсон.
- Шатахууны 8.2 сая төгрөгийн зардлыг шатахууны зарцуулалтын тооцоо хийхгүй шууд зардалд бичсэн.
- Шилэн дансны хуулийн дагуу тухай бүр оруулах 890.6 сая төгрөгийн гүйлгээг оруулаагүй.
- Тайлант үеийн элэгдлийн зардлыг 10.3 сая төгрөгөөр дутуу тооцоолсон.
- НӨАТ-ын авлагын дансанд худалдан авсан суудлын автомашины НӨАТ болох 13.4 сая төгрөгийг илүү бичилт хийсэн.
- Валютин харилцах дансны ханшийн тэгшитгэл алдаатай хийж 668.7 сая төгрөгийг зардлын дансанд давхардуулан бичсэн.
- Нийт 4.9 сая төгрөгийн гүйлгээг буруу данс сонгон бүртгэсэн. Үүнд: 2.9 сая төгрөгийн элэгдлийн зардал, 2.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийн зардал зэрэг болно.

5.2 Албан шаардлага

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлээгүй 4.6 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Валютийн харилцах дансны гүйлгээний болон үлдэгдлийн ханшийн тэгшитгэл алдаатай хийсэн	1	1,561,585.3			1	1,561,585.3	1	1,561,585.3				
Шатахууны тооцоог бодоогүй шууд зардалд бичсэн.	1	8,118.0			1	8,118.0	1	8,118.0				
Шилэн дансны хуулийн дагуу тухай бүр оруулах гүйлгээг оруулаагүй.	1	890,600.2	1	890,600.2			1	890,600.2				
Тайлант үеийн элэгдлийн зардлыг дутуу тооцоолсон.	1	10,346.9			1	10,346.9	1	10,346.9				
НӨАТ-ын авлагын дансны бичилт алдаатай хийсэн.	1	13,386.4			1	13,386.4	1	13,386.4				
Валютийн харилцах дансны ханшийн тэгшитгэл алдаатай хийж 668,744.0 мянган төгрөгийг зардлын дансанд давхардуулан бичсэн.	1	668,744.0			1	668,744.0	1	668,744.0				
Нийт 4,926.1 мянган төгрөгийн гүйлгээг буруу данс сонгон бүртгэсэн. Үүнд: 2,956.1 мянган төгрөгийн элэгдлийн зардлын, 1,970.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжийн зардал зэрэг болно.	1	4,926.1			1	4,926.1	1	4,926.1				
Дүн	7	3,157,706.9	1	890,600.2	6	2,267,106.7	7	3,157,706.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу бусад хэмнэлтийн арга хэмжээ хэрэгжүүлээгүй.	1	4,641.5			1	4,641.5						
Дүн	1	4,641.5			1	4,641.5						



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24 № 555/А.0150116
СНАГ-2023/59/НА-ЦТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс оюу толгой ХХК-ийн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Тайлант хугацаанд зочид төлөөлөгчдөд бэлэг, дурсгалын зүйл худалдан авах 4,641,510.0 /Дөрвөн сая зургаан зуун дөчин нэгэн мянга таван зуун арван/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:... 15.1.5.Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6 "төсвийг зориулалт бусаар зарцуулсан; гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс оюу толгой ХХК-ийн гүйцэтгэх захирал /Н.Цэрэнбат/, Ерөнхий нягтлан бодогч /Г.Мөнхтөр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Я.САМБУУНЯМ

Т.СУГАРСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: \Alban Shuurdaga\2023\0315 SNAG-65 Docx

0001081243

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of multiple sets of three horizontal dashed lines spaced evenly down the page, providing a guide for letter height and placement. The background is plain white, and there are no other markings or text present.

[illegible]

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn
Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс